



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Он энд Он ХХК-ний “Ю-Би” дэн буудлын 16/096, Мөнх Алкес ХХК-ний “Тайга” дэн буудлын 16/120, Иргэн Ж.Болдбаатар “Сити” дэн буудлын 16/031, Уран дринлинг ХХК-ний “Уран” зочид буудлын 13/227, Ээвжнот ХХК-ний “Бамбино” зочид буудлын 16/111, Хөх нуур трейд ХХК-ний “Капелла” зочид буудлын 13/57 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500319

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 11 сарын 15  
өдрийн 16 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.11.15

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хөх нуур трейд ХХК	2056917	Капелла	БЗД-ийн 15-р хороо ЭТӨЧ 47-8
2	Ээвжномт ХХК	5043336	Бамбино	БЗД-ийн 4-р хороо Б.Доржийн гудамж-38
3	Уран дриллинг ХХК	5177499	Уран	БГД-ийн 5-р хороо ЭТӨЧ-49-1
4	Блү Хоорс ХХК	5127327	Кью	БГД-ийн 4-р хороо Нарны зам Кью төвд
5	Блү Хоорс ХХК	5127327	Бэрс	БГД-ийн 6-р хороо Жамсранжав 56
6	Нью пакс Монгол ХХК	5394384	Монголика	ХУД-ийн 12-р хороо Биокамбинат
7	Ноён капитал ХХК	5581664	Амар	БЗД-ийн 13-р хороо 87-3

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 11 сарын 15  
өдрийн АХС дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.11.15

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнх Алкес ХХК	5082919	Тайга	БЗД-ийн 2-р хороо Их дарь эх 1-44
2	Он энд Он ХХК	2562197	Ю-Би	ЧД-ийн 1-р хороо 2-Р 40.000 бага тойруу 41-21
3	Иргэн Ж.Болдбаатар	УЖ61112017	Сити	БЗД-ийн 1-р хороо ЭТӨЧ-13

---ooOoo---